



КРЕДИТ
ББСБ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 4 сарын 17-ны өдөр

№2025/13

Улаанбаатар хот

Компанийн 2024 оны үйл ажиллагааны
болон санхүүгийн тайлангийн
талаар дүгнэлт гаргах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх хэсэг, 80 дугаар зүйл, 96 дугаар зүйлийн 96.1 дэх хэсэг, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журмын 8 дугаар зүйлийн 8.2.5 дахь хэсэг, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны 2025 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 2025/01 тоот дүгнэлт болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон компанийн санхүүгийн тайланд холбогдох хууль тогтоомжийн дагуу “Гранд Торнтон Аудит” ХХК хөндлөнгийн аудит хийж, гаргасан дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.
2. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.
3. Энэхүү тогтоолын хавсралтаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.
4. Хавсралтаар баталсан дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж, зохих шийдвэр гаргуулахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо (В.Ганзориг)-т даалгасугай.
5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо (В.Ганзориг)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ГАНЗОРИГ

2025 оны 4 сарын 17-ны өдөр

№ 2025/44-1

Улаанбаатар хот

ТУЗ-ийн 2025 оны төсөв батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь хэсэг, “Ард Кредит ББСБ” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь хэсэг, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Засаглал, нэр дэвшүүлэх хороо болон Цалин урамшууллын хорооны хамтарсан 2025/01 тоот зөвлөмж, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Ард Кредит ББСБ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны төсвийг Хавсралтаар баталсугай.
2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны төсвийг Компанийн ээлжит Хувьцаа эзэмшигчдийн хуралдаанд танилцуулахыг Аудитын хорооны дарга (В.Ганзориг)-т даалгасугай.
3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдэд олгох цалинг батлагдсан хэмжээгээр заасан хугацаанд олгох, төсвийг зарцуулах, урамшууллыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх хороо болон Цалин урамшууллын хорооноос гаргасан зөвлөмжийн дагуу олгож, холбогдох төлбөр тооцоог хийж гүйцэтгэхийг Гүйцэтгэх захирал (Г.Сүхбаатар)-т даалгасугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо (В.Ганзориг)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ГАНЗОРИГ



КРЕДИТ
ББСБ

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2025 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн
2025/04/17 тоот тогтоолын Хавсралт



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
2025 ОНЫ ТӨСӨВ

	ТУЗ-ийн цалин					
	Үндсэн цалин	Сард олгох	Утга	Давтамж	Гишүүдийн тоо	Нийт
1	ТУЗ-ийн дарга	1,495,000	Тогтмол	12	1	17,940,000
2	Хорооны дарга	1,150,000	Тогтмол	12	4	55,200,000
3	ТУЗ-ийн гишүүн	805,000	Тогтмол	12	4	38,640,000
4	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	1,000,000	Тогтмол	12	1	12,000,000
ТУЗ-ийн урамшуулал						
5	ТУЗ-ийн дарга	8,970,000	Тухайн жилийн компанийн гүйцэтгэл 80 хувиас дээш хангасан тохиолдолд гишүүний үнэлгээнд сарын цалинг 6 үржүүлэн бэлэн мөнгөөр олгох	1	1	8,970,000
6	Хорооны дарга	6,900,000		1	4	27,600,000
7	ТУЗ-ийн гишүүн	4,830,000		1	4	19,320,000
8	Сургалт, хурлын зардал					13,500,000
	Нийт			193,170,000		



КРЕДИТ
ББСБ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр

№ 2025/44-2

Улаанбаатар хот

Сургалтын төлөвлөгөө
батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь хэсэг, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Засаглал, нэр дэвшүүлэх хороо болон Цалин урамшууллын хорооны хамтарсан 2025/01 тоот зөвлөмж, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 4 дугаар сарын 17-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Ард Кредит ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн 2025 оны сургалтын төлөвлөгөөг Хавсралтаар баталсугай.
1. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангуулж сургалтыг зохион байгуулахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Нарийн бичгийн дарга (Г.Есү-Үжин)-д үүрэг болгосугай.
2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо (В.Ганзориг)-т даалгасугай.

ДАРГА



Ч.ГАНЗОРИГ

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2025 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн
105/67-д тоот тогтоолын Хавсралт



	Хугацаа	Сургалтын агуулга	Сургалт орох байгууллага
1.	2025 оны II улирал	Тогтвортой санхүүжилт/БОНЗ	ТОС холбоо
2.	2025 оны II улирал	Банк бус санхүүгийн байгууллагын зохицуулалт эрх зүйн орчин	ББСБ холбоо
3.	2025 оны II улирал	Нээлттэй хувьцаат компанийн ТУЗ-ийн үйл ажиллагаа /Шүтэл үлээх ажиллагаа/	Компанийн Засаглалын төв
4.	2025 оны II улирал	ТУЗ-ийн ритрийт	